



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 8 сарын 21 өдөр

Дугаар А/120

Улаанбаатар хот


Боловсролын зээлийн сангийн
санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дах хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дах хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны “Журам батлах тухай” 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Боловсрол,соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны “Журам батлах тухай” 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хуандаг овогтой Едил Монаш их сургууль, Усны барилга,байгууламжийн магистрантурт 2 жил, Лхагварэнцэн овогтой Сугар Маккауэрийн их сургууль, Бизнесийн удирдлагын магистрантурт 2 жил, Лхагвасүрэн овогтой Эрдэнэчимэг Сиднейн их сургууль, Олон улсын харилцааны магистрантурт 2 жил, Гантөмөр овогтой Хандсүрэн Лондоны харилцааны их сургууль, Бизнесийн удирдлагын магистрантурт 2 жил, Нямжав овогтой Дэлгэржаргал Монаш их сургууль, Бизнесийн удирдлагын магистрантурт 2 жил, Болдням овогтой Мөнх-Оюун Саймон Фразерийн их сургууль, Урлаг судлалын бакалаврт 2 жил Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр тус тус суралцуулсугай.

2. Сангидорж овогтой Байгалмаагийн ОХУ-ын Найрамдлын Их Сургуулийн докторын хамгаалалтын зардлыг Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр санхүүжүүлсүгэй.

3.Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Олон улсын төсөл, хөтөлбөр гадаад хамтын ажиллагааны газар /Ж.Бямбацогт/-д тус тус даалгасугай.



Г. ЧУЛУУНБААТАР